

**ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ****(Захиргааны эрх зүйн маргаан)¹****ӨМГӨӨЛӨГЧ НЬ ШҮҮГЧИЙГ ТАТГАЛЗАН ГАРГАХ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧЭЭСЭЭ ЗӨВШӨӨРӨЛ АВААГҮЙ БОЛ САХИЛГЫН ЗӨРЧИЛД
ТООЦНО**

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2025/0038

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр

Шийдвэрийн төрөл: Гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, гуравдагч этгээдийн давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооноос 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны МТ/2024/** дугаар тогтоолоор өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо өөрийн үйлчлүүлэгчид шүүгчээс татгалзах тухайгаа мэдэгдэж, тайлбарлаагүй нь Өмгөөллийн тухай хууль (2019)-ийг² зөрчсөн гэж үзэж, “сануулах” сахилгын шийтгэл оногдуулжээ.

Гомдол гаргагч өмгөөлөгч нь дээрх тогтоолыг үл зөвшөөрч “Өмгөөллийн тухай хуулийн 13.1.8-д “хуульд заасан үндэслэлээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах” эрхийг өмгөөлөгчид олгосон бөгөөд өөрт олгогдсон эрхийн хүрээнд шүүгчээс татгалзсан” гэж маргажээ.

Харин хариуцагчаас “Гомдол гаргагч өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ зөвшөөрөлгүй шүүгчээс татгалзсан болох нь гомдол гаргагч болон гэрчүүдийн мэдүүлгээр тогтоогддог. Мэргэжлийн хариуцлагын хорооны 2024 оны МТ/2024/** дугаар тогтоолд ямар үндэслэлээр хариуцлага тооцсон нь тодорхой дурдагдсан, бөгөөд Өмгөөллийн тухай хуульд нийцүүлэн шийдвэр гаргасан” гэж тус тус маргасан байна.

Гуравдагч этгээд болох өмгөөллийн үйлчилгээ авч байсан үйлчлүүлэгч иргэн шүүхэд ирүүлсэн тайлбартаа “Мэргэжлийн хариуцлагын хорооноос Өмгөөллийн тухай

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3409?daterange=2025-01-01%20-%202025-09-17&id=3&court_cat=3&bb=1.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №49.



хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж тогтоосон нь зөв боловч “сануулах” шийтгэл оноосон нь хөнгөдсөн гэж үзэж байна” гэж маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Давж заалдах шатны шүүхээс:** Давж заалдах шатны шүүх гомдлыг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхдээ “Өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгч нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлт гаргах эрхтэй байх ба энэ нь хэргийн бусад оролцогч, өмгөөллийн үйл ажиллагааг хамтран явуулж буй бусад этгээд үйлчлүүлэгчийн зөвшөөрлөөс үл хамааралтай хэрэгжихээр байна. Энэхүү хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэнэ” гэх үндэслэлүүдээр Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1³, 4.1.3⁴, 14 дүгээр зүйлийн 14.1.1⁵, 14.1.2⁶, 14.1.6⁷, 15 дугаар зүйлийн 15.1.4⁸-т тус тус заасныг баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.
2. **Гуравдагч этгээдийн давж заалдах гомдлын үндэслэл:** Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөн, мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан болох нь өмгөөлөгчийн өөрийн тайлбар, бусад бичгийн баримтуудаар тогтоогдсон, нэр бүхий 2 шүүгчээс татгалзах хуулийн ямар ч үндэслэлгүй, Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.8⁹, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн¹⁰ 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8¹¹-д заасан заалт нь хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргахаас биш нууцаар үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхол, хүсэл зоригийн эсрэг байр суурийг илэрхийлэх эрхийг олгоогүй болно” гэх үндэслэлээр гуравдагч этгээд давж заалдах журмаар гомдол гаргасан. (3.2)¹²

³ Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт “хууль дээдлэх, шударга ёсыг сахих”.

⁴ Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт “хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэх”.

⁵ Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт “үйлчлүүлэгчид хууль зүйн асуудлаар зөвлөгөө өгч, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр цаг алдалгүй өгөх, өмгөөллийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн агуулга, хууль зүйн үр дагаврыг бүрэн тайлбарлах”.

⁶ Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалт “үйлчлүүлэгчтэй холбоотой гүйцэтгэсэн аливаа үйл ажиллагааны талаар түүнд мэдэгдэх, тайлбарлах”.

⁷ Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалт “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, шийдвэрийг хүндэтгэх”.

⁸ Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, хүсэл зоригийн эсрэг байр суурь илэрхийлэх, эсхүл хэрэг, маргааны эсрэг талд ашигтай аливаа үйлдэл хийх, үйлчлэх, мэдээлэл дамжуулах”.

⁹ Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.8 дахь заалт “хуульд заасан үндэслэлээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах”.

¹⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23.

¹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.8 дахь заалт “мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлт гаргах”.

¹² “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



3. **Хяналтын шатны шүүхээс:** Өмгөөллийн тухай хуулиар олгогдсон татгалзан гаргах тухай эрхийг өмгөөлөгч хэрэгжүүлэх зорилго нь “өөрийн үйлчлүүлэгчийн хүсэл зориг, ашиг сонирхолд үндэслэж, түүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн” байх ёстой тул өмгөөлөгч үйлчилгээ үзүүлж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “үйлчлүүлэгчид хууль зүйн асуудлаар зөвлөгөө өгч, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр цаг алдалгүй өгөх, өмгөөллийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн агуулга, хууль зүйн үр дагаврыг бүрэн тайлбарлах”, 14.1.2-т “үйлчлүүлэгчтэй холбоотой гүйцэтгэсэн аливаа үйл ажиллагааны талаар түүнд мэдэгдэх, тайлбарлах” үүрэгтэй. (10)
4. Энэ тохиолдолд, гомдол гаргагч өмгөөлөгчийг Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2-т заасан үүргээ биелүүлсэн гэж үзэх боломжгүй, энэ талаарх гуравдагч этгээдийн гомдол үндэслэлтэй байна. (11)
5. Иймд Мэргэжлийн хариуцлагын хорооны 2024 оны МТ/2024/*** дугаар тогтоолоор “... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ үйлчлүүлэгчид мэдэгдэж, тайлбарлах ёстой” гэж дүгнэн, өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэсэн нь Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Хууль болон энэ дүрэмд заасан үүрэг, шаардлагыг зөрчсөн өмгөөлөгчийн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчилд тооцно” гэж заасанд нийцжээ. (12)
6. Харин давж заалдах шатны шүүх “... өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгч нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлт гаргах эрхтэй байх ба энэ нь хэргийн бусад оролцогч, өмгөөллийн үйл ажиллагааг хамтран явуулж буй бусад этгээд үйлчлүүлэгчийн зөвшөөрлөөс үл хамааралтай хэрэгжихээр байна” гэж дүгнэн, Мэргэжлийн хариуцлагын хорооны 2024 оны МТ/2024/*** дугаар тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэл бүхий болж чадаагүй байна. (13)
7. Энэ маргааны хувьд, үйлчлүүлэгч “өмгөөлөгч шүүгчээс татгалзах хуульд заасан үндэслэл байгаагүй” гэх агуулгаар өмгөөлөгчийн үйл ажиллагааг эс зөвшөөрөн маргаж буй нөхцөлд, өмгөөлөгч үйлчлүүлэгчид мэдээлэл өгөх, мэдэгдэх, хууль зүйн үр дагаврыг бүрэн тайлбарлах зэрэг хуульд заасан үүргийг зөрчсөн эсэхэд дүгнэлт өгөхгүйгээр “шүүгчээс татгалзах хүсэлт гаргах эрхийг өмгөөлөгчид олгосон хязгааргүй” эрх мэтээр давж заалдах шатны шүүх тайлбарлан хэрэглэсэн нь буруу. (14)
8. Дээрх үндэслэлүүдээр гомдол гаргагчийн гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан бүхий тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, гуравдагч этгээдийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хангасан байна.



---o0o---